




ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР
Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга
хэмжээ, вакцинжуулалт болон Монгол мал
үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт
ХөААГ – 2013/07-НÀ

*Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө удирдамжийн дагуу хийсэн
нийцлийн аудитын тайлан.*



**ПАРАЗИТТАХ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ АРГА
ХЭМЖЭЭНД ТӨРИЙН ДЭМЖЛЭГ
ДУТАГДАЛТАЙ БАЙНА.**

2013 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үг	3
ААГ-ын Гүйцэтгэлийн аудитын баг 2 Ерөнхий аудитор: Г.Оюунгэрэл	Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй	4-7
Утас: 96665871	Нэг. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт учир дутагдалтай байна.	
Аудитын менежер:	1.1. Аймаг батлагдсан хууль, тогтоомж, эрх зүйн актыг малчин өрх, иргэдэд сурталчилсан байна.	7-10
Г.Эрдэнэчимэг Утас: 99016320	1.2. Төлөвлөгөө боловсруулахтай холбогдуулан судалгаа, шинжилгээ хийгээгүй байна.	10-11
Ахлах аудитор:	1.3 .Хөтөлбөр аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдан хэрэгжиж байна.	11-12
Л. Энх-Амгалан Утас: 96383478	1.4 Сумдын мал эмнэлэг, үржлийн тасаг мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байна.	12-13
Шинжээч:	1.5 Хөтөлбөр төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа боловч хэрэгжилтийн бодит байдлыг тооцоход хүндрэлтэй байна. .	13-14
Б.Сандуйжав Утас: 99380020	1.6 Хөтөлбөрийг аймагт хэрэгжүүлэх төлөвлөгөөнд хүрэх түвшинг тодорхойлоогүйгээс 2010-2012 оны үзүүлэлтүүдийн хангалтыг тооцох боломжгүй байна.	15-17
Шинжээч:	1.7 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийж буй хяналт шинжилгээ, үнэлгээ бодитой биш байна.	17-20
Н.Бямбадорж Утас: 99996756	1.8 Зарим хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулсан байна.	20
Шинжээч:	1.9 Хөтөлбөрийн хүрээнд хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн зарим тоног төхөөрөмж ашиглагдахгүй байна.	20-21
Ч.Хуншагай Утас: 99388787	1.10 Хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдсэн ээмэг чанарын шаардлага хангахгүйгээс ээмэгжүүлэлт, бүртгэлийн ажил удаашралтай байна.	21-22
2013 оны 06 дугаар сар	Хоёр. улсын төсвөөс нийлүүлэх эм бэлдмэлийг бүрэн нийлүүлээгүйгээс паразиттах өвчнийг эмчлэн сэргийлэх арга хэмжээ хангалтгүй байна.	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70384043 дугаарын утас, 70383793 дугаарын факсаар харилцана уу?	2.1 Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардлагатай үйлчилгээний хөлсийг орон нутгийн төсвөөс бүрэн санхүүжүүлж чадахгүй байна.	22-23
	2.2 Вакцинжуулалтын захиалгыг үндэслэн Биокомбинат ТӨҮГ нь хөрөнгө оруулалтаар нийлүүлж байна.	23-24
	2.3 Лабораторийн шинжилгээнд хамрагдсан эм тарилга, вакциныг нийлүүлж байна.	24
	2.4 Халдварт өвчний гаралт буурч байна.	24-26
	2.5 Мал эмнэлгийн алба нь голомтын бүртгэл гаргаж хянаж байна.	27
ХАЯГ: (Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын А байр)	Дүгнэлт:	28
	Зөвлөмж:	28-29
	Холбогдох байгууллагын санал:	30

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУ	Монгол улс
УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ҮХААЯ	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
ДМАЭМБ	Дэлхийн мал амьтан эрүүл мэндийн байгууллага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгч
ААГ	Аймгийн Аудитын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ҮХААЯ	Үйлдвэр,Хөдөө аж ахуйн яам
УМЭҮГ	Улсын мал эмнэлэг үржлийн газар
ХХААЖДҮГ	Хүнс,Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ЖДҮДС	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
МЭХ	Мал эмнэлгийн хүрээлэн
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МЭҮТ	Мал эмнэлэг үржлийн тасаг
МЭА	Мал эмнэлгийн алба
БЗА	Бодлого зохицуулалтын алба
АХЦБӨ	Адууны халдварт цус багадах өвчин
ББН	Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХААИС	Хөдөө аж, ахуйн их сургууль

Аудитын зорилт, хамрах хүрээ, асуудлууд

Хөвсгөл аймгийн Аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд ҮАГ-аас ирүүлсэн аудитын удирдамжийн дагуу “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, вакцинжуулалт болон Монгол мал үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт”-нд нийцлийн аудит хийв.

Аудитын зорилт

Мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээ, вакцинжуулалт болон Монгол мал үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг шалган дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан холбогдох албан байгууллагад танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийсэн. Үүнд:

-  Монгол мал үндэсний хөтөлбөр зохих ёсоор хэрэгжиж байгаа эсэх
-  Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, вакцинжуулалтын ажил хууль тогтоомжийн дагуу хэрэгжиж байгаа эсэх

Аудитын хамарсан хүрээ:

Аймгийн хэмжээнд “Монгол мал үндэсний хөтөлбөр”-ийг удирдан зохион байгуулах, зохицуулах үүргийг хэрэгжүүлэх аймгийн Засаг дарга, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ХХААЖДҮГ болон аймгийн ЗДТГазрын Хөгжлийн бодлогын хэлтэс хамрагдана.

Аудитын явцад холбогдох байгууллагын албан тушаалтануудтай ярилцлага хийх, санал солилцох, ирүүлсэн судалгаа, иргэд нийтийн хурлаар хэлэлцүүлсэн байдал, удирдлагын шийдвэр, холбогдох бусад материалд судалгаа, шинжилгээ хийсний дүнд ерөнхий эрсдлийг “**ДУНД**” гэж үзлээ.

Аудитын арга зүй

Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, нийцлийн аудитын гарын авлага, төлөвлөгөө, асуудлын шинжилгээнд тодорхойлсон арга зүйг ашиглав.

Аудитын явцад Хөгжлийн бодлогын хэлтэс, ТЗУХэлтсийн хяналт шинжилгээ, үнэлгээний тасаг болон ХХААЖДҮГазрын холбогдох мэргэжилтнээс асууж тодруулах, ярилцлага хийх, баримт материалыг судлах, дүн шинжилгээ хийсний

дүнд Төрийн хяналт шалгалтын стандарт, аудитын аргазүй, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудит хийсэн бүрэлдэхүүн

Энэхүү аудитыг ерөнхий аудитор Г.Оюунгэрэл удирдаж, аудитын менежер Г.Эрдэнэчимэг арга зүйгээр хангаж, явцын болон чанарын хяналтыг тавьж, гүйцэтгэлийн аудитын багийн ахлагч, ахлах аудитор Л.Энх-Амгалан, шинжээч Н.Бямбадорж, Б.Сандуйжав, Ч.Хуншагай нар 2013 оны 5 дугаар сарын 24-нөөс 2013 оны 6 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэв.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.



Үндсэн мэдээлэл

Хөвсгөл аймаг нь улсдаа хамгийн олон буюу 3601673 толгой малтай. Үүнээс тэмээ 2104, адуу 161203, үхэр 322113, хонь 1673087, ямаа 1443166 толгой мал тус тус байна.

УИХ-ын 2010 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 23 дугаар тогтоолоор “Монгол мал” үндэсний хөтөлбөр батлагдсан. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хэсгийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011оны 44 дүгээр тогтоолоор томилсон байна.

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийг 2010-2015 онуудад Хөвсгөл аймагт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Хөвсгөл аймгийн Засаг даргын 2011 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/153 тоот захирамжаар баталж төлөвлөгөөний дагуу хөтөлбөр хэрэгжиж байна.

Хөтөлбөрийн зорилго нь мал аж ахуйг уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж, зах зээлийн нөхцөлд өрсөлдөх чадвартай, эдийн засгийн үр ашигтай салбар байх нөхцлийг бүрдүүлж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангаж, уламжлалт мал аж ахуйг шинжлэх ухааны ололт, технологиор баяжуулан бүтээмжийг нь нэмэгдүүлэхэд чиглэгдэж байгаа болно.

Хөтөлбөр хэрэгжсэнээр улс орон нутгийн төдийгүй манай аймгийн тухайд өндөр ашиг шимтэй, эрүүл мал аж ахуйн бүтээгдэхүүнийг экспортлох, түүхий эд, бүтээгдэхүүний гарц, чанарыг сайжруулж, дэлхийн төвшинд хүргэх, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх бололцоо бүрдэх юм.

Хөтөлбөрийг 2010-2021 онд хоёр үе шаттайгаар төлөвлөж, эхний үе шатыг 2010-2015 онд 5 тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

1. Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангаж, эдийн засгийн эргэлтэд эрчимтэй оруулах тогтолцоог бий болгох эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх.
2. Мал аж ахуй эрхлэх уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгож бэлчээрийн болон эрчимжсэн аж ахуйг зохистой хослон хөгжүүлж малын үржлийн ажил үйлчилгээг сайжруулж бүтээмжийг нэмэгдүүлэн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх.

3. Эрүүл малаас цэвэр, аюулгүй түүхий эд, бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлэх нөхцлийг бүрдүүлэх
4. Монгол Улсад бэлчээрийн мал аж ахуйг зонхилон, эрчимжсэн мал аж ахуйг тодорхой бүс нутагт хязгаарлагдмал хүрээнд эрхлэн, бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх, тэжээл үйлдвэрлэл, хангамжийг сайжруулах замаар мал аж ахуйн эрсдэлийг бууруулах.
5. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэлийн системийг боловсронгуй болгож түүний чанараас хамаарсан эдийн засгийн хөшүүрэг бий болгон зорилтот зах зээлийг хөгжүүлэх.

Хөтөлбөрийн тайланг аймгийн ХХААЖДҮГ нь жил бүрийн 1 дүгээр сард багтаан аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэст ирүүлдэг. Аймгийн ЗДТГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээний тасаг нь хөтөлбөрийн явцад хяналт хийж, биелэлтийг нь тооцон ажиллаж байна.

Мал амьтныг олноор өвчлүүлж, улс орны эдийн засагт ихээхэн хохирол учруулдаг, олон улсын худалдаанд хорио цээр тавигддаг 15 нэрийн өвчнийг ДМАЭМБ-аас гоц халдварт өвчинд тооцдог ба эдгээрээс манай аймагт өмнө нь гарч байсан болон одоо гарч байгаа 5, гарах эрсдэл бүхий 4 төрлийн өвчин байна. Сүүлийн 30 жилд жил бүр нэг өвчин шинээр оношлогдож байгаагийн 60 хувь нь мал амьтнаас хүнд дамжин халдварладаг, вирусээр үүсгэгддэг халдварт өвчин байна. Манай орны мал сүргийн дунд гарч хүн, малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, улс орны эдийн засагт хохирол учруулдаг 35 нэрийн халдварт өвчин бүртгэгдсэн байдаг бөгөөд манай аймагт голомтын судалгааг гаргаж түүнд тандалт шинжилгээг жил бүр хийж хянаж байна.

Малын халдварт боом өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд 2009 -2012 онд голомт, эрсдэл бүхий газраар Хөвсгөл аймаг хамрагдаж бруцеллёз болон галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх эм,вакцинжуулалтын зардалд улсын төсвөөс 2010 онд 234567,0 мянган төгрөг, 2011 онд 250843,5 мянган төгрөг, 2012 онд 950280,7 мянган төгрөг зарцуулжээ. МЭУСАХЗардалд 2011 онд 184200.0 мянган төгрөг, 2012 онд 395652,0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс тус тус санхүүжүүлсэн байна.

Манай аймгийн мал сүрэгт 10-аад нэрийн паразиттах өвчин гарч мал хорогдох, тарга хүч буурах, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн чанарыг бууруулах зэргээр ихээхэн хохирол учруулдаг байна. Мал сүргийг паразиттах өвчнөөс эрүүлжүүлэх, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд төр засгаас анхаарч угаалга, туулгалт, боловсруулалтанд шаардагдах эм, бэлдмэлийн санхүүжилтыг улсын төсвөөс, үйлчилгээний зардлыг өмчийн эзэд хариуцан хэрэгжүүлж байгаа боловч 2010, 2011 онд паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд шаардагдах бэлдмэлийг Хөвсгөл аймагт нийлүүлээгүй байна.

Хөвсгөл аймгийн ХХААЖДҮГ-ын Мал эмнэлгийн алба нь орон нутагтаа мал эмнэлгийн ажил үйлчилгээний хүрээ чанарыг дээшлүүлэх, мал амьтныг халдварт, халдварт паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, устгах, шинжлэх, оношлох, тандах, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлын үр өгөөжийг дээшлүүлэх,

зорилт тавин шинжлэх ухаан технологийн дэвшилд тулгуурлан ЗГ-аас хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн ажлыг тэргүүлэх зорилт болгон ажиллаж байна.

1.1 Батлагдсан хууль, тогтоомж, эрх зүйн актыг малчин өрх, иргэдэд сурталчилсан байна.

“Монгол мал” үндэсний хөтөлбөр нь МУ-ын Их хурлын 2010 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд Засгийн газрын 2010 оны 222 дугаар тогтоолоор баталсан “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн эхний үе шатыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1-д “Мал аж ахуйн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох” талаар дараах 3 чиглэл тусгасан байна. Үүнд:

1. Мал аж ахуйн салбар дахь хууль тогтоомжийг боловсронгуй болгох
2. Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг олон улсын жишигт хүргэх
3. Мал аж ахуйн мэргэжилтэн, малчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, үйлдвэрлэлд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх

Энэхүү төлөвлөгөөтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2011 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/153 тоот захирамжаар “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн эхний үе шатанд хэрэгжүүлэх 53 заалт бүхий төлөвлөгөөг батлан ажиллаж байна.

Мал аж ахуйн салбартай холбоотойгоор манай улсад дараах хууль, эрх зүйн актууд мөрдөгдөж байна. Үүнд:

- Мал, тэжээвэр амьтны удмын сан, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор “Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах хууль”,
- Хүний болон мал эмнэлгийн зориулалттай эм, түүний дотор уламжлалт эм, биобэлдмэл, оношлуур эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхит бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаатай холбогдуулан “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”,
- Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үед мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль”,
- Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбоотой “Амьтны тухай хууль”,
- Малын эм, тарилга, вакцинжуулалтын худалдан авалттай холбоотойгоор “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”,
- “Монгол улсын үндсэн хууль” гэх мэт холбогдох хууль эрх зүйн акт

Эдгээр хууль эрх зүйн актуудаас гадна мал аж ахуйн салбар дахь хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр дараах ажлууд хийгдсэн байна.

Үүнд:

- ❖ Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийг үүсгэн байгуулах, түүний зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох зорилгоор “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийг УИХ-ын 2011 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн нэгдсэн хурлаар баталсан байна.
- ❖ Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох, тэмээ, хонины ноос, бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгоход бонд гарган дэмжлэг үзүүлэх зорилгоор “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2011 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 30 дугаар тогтоол гарсан.
- ❖ “Мал хамгаалах сангийн тухай” журмын төслийг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар баталсан байна.

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2011 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/153 тоот захирамжаар баталсан төлөвлөгөөний 1 дэх заалтад “Шинээр батлагдан гарсан болон нэмэлт өөрчлөлт орсон хууль эрх зүйн актуудыг сурталчлан таниулах, хэрэгжүүлж ажиллах, зохион байгуулалтын арга хэмжээ авах гэж” тусгасан байна. Энэхүү заалтын хүрээнд:

- “Төрийн бодлого, малчны санаачилга, нутгийн зөвлөлийн оролцоо” сэдэвт зөвлөлгөөнийг нийт 24 сумын 5300 гаруй малчдыг хамруулан “Монгол мал” үндэсний хөтөлбөр, “Биржийн тухай хууль” болон бусад хууль эрх зүйн актуудыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан байна.
- Мөн Аймгийн ЗДТГ, ХХААЖДҮГ, ЭМГ, Малчдын холбоо, Татварын хэлтэс зэрэг байгууллагууд хамтран “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол мал” үндэсний хөтөлбөр, “Биржийн тухай хууль” Ноосны урамшуулалд хамрагдах боломж, Малчдын эрүүл мэндийн талаар болон татварын эрх зүйн орчны тухай “Буянт малын эзэд” сургалтыг 2012 оны 05 дугаар сард зохион байгуулж 88 багийн 6000 гаруй малчид хамрагдсан байна.
- Рэнчинлхүмбэ, Цагаан-Уул, Цагаан-Үүр зэрэг сумын МЭҮТ-аас тус хөтөлбөр болон холбогдох хууль эрх зүйн актыг танилцуулга тараах материал бэлтгэн танилцуулсан байна.

Шинээр батлагдан гарсан болон нэмэлт өөрчлөлт орсон хууль эрх зүйн актуудыг сурталчлан таниулах, хэрэгжүүлж ажиллах зохион байгуулалтын арга хэмжээ авах төлөвлөгөөний дагуу дээрх арга хэмжээ, үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан хэдий ч малчдын мал маллагааны боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, байгаль, цаг уурын эрсдэл даах болон зах зээлд өрсөлдөх чадвар бүхий мал бэлдэх, бэлчээр ашиглалт, малаас хүнд дамжин халдварладаг зарим өвчний тархвар, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх талаарх сургалт мэдээллийг малчдад түлхүү хүргэж ажиллах шаардлага байна.

Мал аж ахуйн мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах зорилгын хүрээнд:
- Мал эмнэлэг үржлийн тасагт шинээр томилогдсон мэргэжилтнүүдээс болон малын эмчээр төгссөн 6 мэргэжилтэн мал аж ахуйн чиглэлээр оройн ангид, Хөдөө аж ахуйн биотехнологийн сургуульд мэргэжил дээшлүүлсэн байна. Мал эмнэлгийн техникч бэлтгэх 45 хоногийн сургалтыг 2012 оны 03 дугаар сард ХААИС-тай хамтран зохион байгуулж 33 хүн хамрагдаж төгссөн байна. Үүнийг мал эмнэлгийн үйлчилгээг үзүүлж байгаа 61 аж ахуй нэгжийн тоотой харьцуулахад 54 хувийг эзэлж байгаа нь цаашид мэргэжилтэнг сургах шаардлага байгааг илэрхийлж байна.

МУ-ын Засгийн газрын 2010 оны 222 дугаар тогтоолоор баталсан төлөвлөгөөний 1 дэх хэсгийн 2, 3 дахь зорилт, хөтөлбөр хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөөний дагуу тодорхой ажлууд хийгдсэн байна. Үүнд:

- ✓ Мал эмнэлэг, үржлийн загвар аж ахуй бий болгох зорилтын хүрээнд Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслөөр Тариалан сумын “Эрхэмцогт” ББН-д ажлын байр барьж байгуулах, Рэнчинлхүмбэ сумын “Сарьдаг” ХХК зэргийг загвар аж ахуй нэгж болгохоор тус төслөөс дэмжин ажилласан байна.
- ✓ Аймгийн лабораторийн мэргэжилтнүүдийг улсад, сумын МЭҮТасгийн мэргэжилтнүүдийг аймагт зохион байгуулсан шаталсан сургалтанд 28 хүн хамрагдсан. 2010 онд МЭА-ны дарга томуутай тэмцэх туршлага судлах, 2010 онд халдвартын эмч хил дамжин халдварладаг өвчний оношлогоо, 2011 онд лабораторийн эрхлэгч, ийлдэс судлаач эмч нар шүлхий өвчний лабораторийн оношлогоо сургалтанд тус тус хамрагдсан байна.
- ✓ Бүх сумын МЭҮ-ийн тасаг GPS-ээр хангагдсан ба одоогоор халдварт өвчний 207 голомтын байршлыг тодорхойлсон байна.

Аймгийн ХХААЖДҮГ-аас хөтөлбөр хэрэгжүүлэхэд эрх зүйн орчинтой холбоотой дараах хүндрэл байгааг дурьджээ. Үүнд:

- ✓ УИХ-ын 2010 05 дугаар сарын 20-ны өдрийн 23 дугаар тогтоолын 3-т “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг Монгол Улсын нэгдсэн төсвийн 3 хувиас багагүй байхаар тооцож жил бүрийн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн

чиглэл, улсын төсөвт тусгаж, хөрөнгийн дийлэнх хэсгийг хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хөдөө аж ахуйн хоршоог түшиглэн хэрэгжүүлэх” гэж заасныг УИХ-ын 2011 оны 12 сарын 23 өдрийн 64 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг бүрэн батлуулах эрх зүйн орчин дутагдалтай болсон.

- ✓ Сум бүрт хөтөлбөрийг удирдан зохион байгуулах, зохицуулах үүрэг бүхий анхан шатны нэгж байгуулагдсан боловч шаардлагатай урсгал зардлууд нь сумын Засаг даргын тамгын газрын санхүүжилтэд багтдаг.

Эдгээр хүндрэл нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тусгайлсан санхүүжилт байдаггүйгээс бие даасан үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарлаж байна.

Тайлангийн 1.6 дахь хэсэгт үзүүлсэн үзүүлэлтүүдээс харахад: Малын индексжүүлсэн даатгалд 2012 онд малчид хамрагдаагүй байна. Энэ нь даатгалын нөхөн олговрын шалгуур үзүүлэлт болох малын хорогдлын хувь, хэмжээ өндөр байгаагаас малчид даатгалд хамрагдах сонирхолгүй байгаатай холбоотой байна.

1.2 Судалгаа, шинжилгээ хийхгүйгээр хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулсан байна.

Монгол мал хөтөлбөрийн хүрээнд мал амьтдыг вакцинжуулах, ээмэгжүүлэх, тандалт шинжилгээ зэрэг үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж байгаа бөгөөд МЭУСАХ-ний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төсөв батлагдан хэрэгжиж байна. Харин тус хөтөлбөрийн үйл ажиллагаатай холбоотой санхүүжилтийг тусгайлан орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төсөв батлагдаагүй байна.

ХХААЖДҮГ-ын МҮА-ны дарга Г.Баттулга “Монгол мал” хөтөлбөрийн хүрээнд тус аймагт дараах судалгааны ажлуудыг хийсэн талаар тайлбар ирүүлсэн.Үүнд:

- Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 2009 онд “Оюунбадрах” ХХК нь Түнэл, Алаг-Эрдэнэ, Арбулаг, Бүрэнтогтох, Их-Уул, Мөрөн, Шинэ-Идэр, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Цэцэрлэг зэрэг 11 сумдын 80 цэгт усны хайгуулын ажлыг хийж 69 уст цэгийг тогтоосон.
- 2012 онд Галт, Эрдэнэбулган, Шинэ-Идэр, Бүрэнтогтох, Алаг-Эрдэнэ, Түнэл, Чандмань-Өндөр, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Тариалан, Арбулаг, Их-Уул, Рашаант, Цэцэрлэг, Цагаан-Үүр, Баянзүрх, Цагаан-Уул, Мөрөн зэрэг 18 сумын 52 багийн нутаг 81 цэгт усны хайгуулын ажлыг зохион байгуулж 70 уст цэгийг тогтоосон байна.
- ҮХААЯам, ургамал хамгааллын хүрээлэнтэй хамтарч жил бүрийн хаварт тандалт судалгааны ажлыг 5 сумын нутагт зохион байгуулан ажилладаг.

Ажлын үр дүнг харгалзан хуваарь батлаж, энэхүү хуваарийн дагуу ажилладаг.

- Малын халдварт зарим төрлийн өвчнөөс эрүүлжих, зарим өвчнийг үе шаттайгаар бууруулах, урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг боловсруулахдаа улсын хэмжээнд гардаг халдварт өвчний гаралт, тархалт, өсөлт бууралтын судалгаа, шинжилгээг үндэслэн олон улсын түвшинд тавигдах шаардлагад нийцүүлэн үе шаттайгаар эрүүлжүүлэх, бууруулахаар төлөвлөн хэрэгжүүлж байна” гэжээ.

Дээрхи судалгаа шинжилгээ нь хөтөлбөр хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөө боловсруулах үе шаттай төдийлэн уялдаагүй байна.

Аймгийн төлөвлөгөөг боловсруулахдаа судалгаа, шинжилгээ хийсэн эсэх талаар аймгийн ХХААЖДҮГ-ын МҮА-ны дарга Г.Баттулгаас тодруулахад: *“төлөвлөгөөг гаргахдаа Засгийн газрын 2010 оны 222 дугаар тогтоолоор баталсан “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн эхний үе шатыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан заалтуудаас аймагт холбогдох заалтуудыг авч хийсэн, төлөвлөгөө боловсруулахтай холбогдуулан тооцсон судалгаа, хийсэн шинжилгээгүй”* гэсэн тайлбар өгсөн. Засгийн газрын тогтоолоор баталсан төлөвлөгөөтэй аймгийн Засаг даргын тушаалаар баталсан төлөвлөгөө хэрхэн нийцэж байгааг харьцуулан **үзэхэд**: Аймгийн төлөвлөгөөнд Засгийн газрын тогтоолоор баталсан төлөвлөгөөний аймагт хамаарах заалтуудыг тусгасан байгаа ч дараах заалтуудыг орхигдуулсан байна. Үүнд:

- Отрын нөөц бэлчээрийг ашиглах журмыг боловсруулах
- Сум бүр бэлчээрийн болон эрсдэлийн удирдлагын жилийн төлөвлөгөөг малчид, иргэдийн оролцоотойгоор боловсруулан хэрэгжүүлэх
- Мал, мах бэлтгэл болон технологийн тээвэр бүхий борлуулалтын нэгдсэн сүлжээ бий болгох

Аймгийн Засаг даргын захирамжаар баталсан төлөвлөгөө нь Засгийн газрын тогтоолоор баталсан төлөвлөгөөтэй уялдсан байдлыг **хавсралт 1**-ээр харуулав.

1.3 Хөтөлбөр аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдан хэрэгжиж байна.

Аймгийн ИТХ-аас баталсан жил бүрийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд хүнс, хөдөө, аж ахуйн чиглэлээр 2010 онд 22 заалт, 2011 онд 8 заалт, 2012 онд 19 заалтыг тусгасан байна. Эдгээр заалтуудад “Монгол мал” үндэсний хөтөлбөртэй уялдсан байдлыг хүснэгтээр хавсралт 2-оор харуулав.

Хавсралт-2 оос харахад Хөвсгөл аймгийн эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан хүнс, хөдөө аж ахуйн чиглэлийн 8 заалт, 2012 оны үндсэн чиглэлд тусгасан 19 заалтаас 18 заалт нь “Монгол мал” хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээтэй уялдсан байна.

1.4 Сумдын мал эмнэлэг, үржлийн тасаг мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байна.

Аймгийн ИТХТ-ийн 2011 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 44 дүгээр тогтоолоор “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг аймагт хэрэгжүүлэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргаар ахлуулан байгуулсан байна. 2010 онд сумдын Засаг даргын Тамгын газрын бүтцэд мал эмнэлэг, үржлийн үйлчилгээг зохицуулах, хянах, мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий нэгжийг байгуулах тухай Засгийн газрын 223 дугаар тогтоол болон ХХААХҮЯ Сайдын А/230 дугаар тушаал гарсантай холбогдуулан тус аймгийн 23 суманд мал эмнэлэг, үржлийн тасаг байгуулагдан нийт 68 мэргэжилтэн ажиллаж байна. Энэхүү тасаг нь сумдад “Монгол мал” хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулж байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2011, 2012 онуудад сумдын¹ мал эмнэлэг, үржлийн тасаг нь журмын дагуу байгуулагдсан байдал, тасагт томилогдсон мэргэжилтнүүд ажлын байрны шаардлага хангаж байгаа эсэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах сумын төлөвлөгөө, мэргэжилтнүүд ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаад шалгалт хийсэн байна. Шалгалтын дүнд дараах зөрчил дутагдал илэрчээ. Үүнд:

- Жаргалант, Чандмань-Өндөр, Ханх сумдын мал эмнэлэг, үржлийн тасагт томилогдон ажиллаж байгаа бэлчээрийн менежмент, газар тариалан, хоршоо, ЖДҮ, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтний мэргэжил, боловсролын түвшин нь ажлын байранд тавигдах шаардлага хангаагүй
- Галт суманд малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн, Алаг-Эрдэнэ, Чандмань-Өндөр суманд мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологи, үржил, бүртгэл хариуцсан мэргэжилтэнг томилоогүй
- Цагаан-Үүр, Эрдэнэбулган, Ханх сумдын мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологи, үржил, бүртгэл хариуцсан мэргэжилтэн нь мэргэжлийн бус
- Цагаан-Үүр, Цагаан-Уул сумдын малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн, Рашаант сумын бэлчээрийн менежмент, газар тариалан, хоршоо, ЖДҮ, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн нар нь журмын шаардлага зөрчиж томилогдсон.

¹ Цагаан-Уул, Жаргалант, Шинэ-Идэр, Галт, Төмөрбулаг, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Эрдэнэбулган, Ханх, Цэцэрлэг, Тариалан, Их-Уул, Тосонцэнгэл, Баянзүрх, Ренчинлхүмбэ, Цагааннуур, Бүрэнтогтох, Арбулаг, Улаан-Уул, Алаг-Эрдэнэ.

Аймгийн МХГазраас “суманд хэрэгжүүлэх мэргэжлийн ажил, үйлчилгээг эзэнгүйдүүлэх, мал эмнэлэг, үржлийн тасгийн ажил цалгардах нөхцлийг бүрдүүлж байна” гэж үзэн зөрчил арилгах албан шаардлага, үүрэг даалгавар өгч ажиллажээ. Шалгалтын үр дүнд “ажлын байрны шаардлагад нийцсэн мэргэжлийн албан хаагч томилуулах талаар тодорхой ахиц гарсан бөгөөд одоогийн байдлаар Цагаан-Уул сумын малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн, Алаг-Эрдэнэ сумын мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологи, үржил, бүртгэл хариуцсан мэргэжилтэн нар нь ажлын байранд тавигдаж байгаа шаардлагыг хангахгүй байна” гэж аймгийн МХГ-ын улсын байцаагч Ц.Эрдэнэ дүгнэсэн байна.

Тасгийн ажилтнууд нь ажлын байрны тодорхойлолтод заагдсан шаардлагуудыг хир ханган ажиллаж байгаа байдлыг аудитын явцад судалгаа гаргуулан хянан үзэхэд **хөтөлбөрийг удирдан зохион байгуулах анхан шатны нэгжийн мэргэжлийн боловсон хүчин хангалттай байна** гэж үзлээ. Харин сумдын Мал эмнэлгийн тасгуудад учирч байгаа хүндрэл бэрхшээлийн талаарх мэдээллийг *тайлангийн 1.10-д дурьдсан болно.*

1.5 Хөтөлбөр төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа боловч хэрэгжилтийн бодит байдлыг тооцоход хүндрэлтэй байна.

Засгийн газрын 2010 оны 222 дугаар тогтоолоор баталсан “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн эхний үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан аймгийн Засаг даргын 2011 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/153 дугаар захирамжаар баталсан “Монгол мал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан заалтуудын хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын ХБХ болон аймгийн ХХААЖДҮГ-аас тухайн он оноор тооцон гаргажээ. Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойшхи төлөвлөгөөний биелэлтийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 2

Он	Төлөвлөгөөний биелэлт /хувиар/
2011	67,0
2012	88,8

Аймгийн ЗДТГ-ын ХБХ болон аймгийн ХХААЖДҮГ-аас төлөвлөгөөний биелэлтийг хүснэгт2-д үзүүлсэний дагуу гаргасан байгаа ч тухайн онд хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт тодорхойгүй байгаа нь төлөвлөгөөний хэрэгжилтийг үйл ажиллагаагаар тайлагнаж, түүнд үнэлгээ хийж байгааг харуулж байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт тодорхой бус байснаас аудитын явцад хэрэгжилтийн бодит байдлыг тооцон гаргахад хүндрэлтэй байсан болно.

Төлөвлөгөөний хэрэгжилтийг 2012 оны жилийн эцсийн байдлаар дүгнэн үзэхэд дараах заалтууд хангалтгүй гарсан байна.

Хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 3

Төлөвлөгөөний заалт	Тайлбар
Бүрэн найрлагат тэжээл үйлдвэрлэх жижиг оврын цех байгуулах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх төсөл шалгаруулж, жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас дэмжлэг үзүүлэх	Энэ чиглэлээр иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн санал хүсэлт байхгүй байна.
Цас, борооны усыг тогтоож, хөв цөөрөм байгуулах үйл ажиллагааг дэмжих	Энэ чиглэлээр ажил хийгдээгүй байна.

Хүснэгтэнд үзүүлснээр бүрэн найрлагат тэжээл үйлдвэрлэх үйлдвэрлэлийн талаар иргэдэд сурталчлан таниулах, сургалт зохион байгуулах, хөв цөөрөм байгуулах ажилд анхаарах шаардлагатай нь тус тус харагдаж байна.

1.6 Хөтөлбөрийг аймагт хэрэгжүүлэх төлөвлөгөөнд хүрэх түвшинг тодорхойлоогүйгээс 2010-2012 оны үзүүлэлтүүдийг хангалтыг тооцох боломжгүй байна.

“Монгол мал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан аймгийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудын хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тогтоогоогүй зөвхөн хөтөлбөрийн хүрээнд хийгдэх үйл ажиллагааг зааж өгсөний дагуу хөтөлбөрийн хэрэгжилтийг жил жилээр нь тайлагнаж байна. Иймд тодорхой зорилтонд хүрсэн эсэхийг тодорхойлж үнэлэх боломжийг бүрдүүлээгүй байна.

Аймгийн ХХААЖДҮГ-ын БЗА, МЭА, МҮАлбанаас төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийг дараах байдлаар гаргасан байна.

Монгол мал хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Хүрсэн түвшин	
			2011 он	2012 он
1	Мал эмнэлэг, үржлийн анхан шатны нэгжийг бэхжүүлэх:	Төрийн үйлчилгээний алба	тоо	23
		Хувийн хэвшлийн үйлчилгээний	тоо	58
2	Мал аж ахуйн мэргэжилтэн, малчдын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх:	Шинээр бэлтгэх, давтан сургах мэргэжилтний тоо	тоо	2
		Малчны түр сургууль төгсөгчдийн тоо	тоо, өссөн	24
3	Малын удмын санг хамгаалах ажлын хүрээнд:	Мал үржүүлэг, биотехнологийн салбар	тоо	1
		Зохиомлоор хээлтүүлсэн малын тоо	23	513
4	Мал үржүүлгийн бүтээгдэхүүний тоо	дотооддоо үйлдвэрлэсэн үр, хөврөл үр	тоо	*
		импортлосон үр, хөврөл үр	тоо	*
5	Оны эхэнд тоологдсон малын тоо	үүнээс: төрөл тус бүрээр:	мян.тол	3315515
		Тэмээ	хувь	0.06
		Адуу	хувь	4.6
		Үхэр	хувь	9.4
		Хонь	хувь	43.9
		Ямаа	хувь	41.8
6	Нэг малаас авсан ашиг шим:	Цэвэр, эрлийз үнээний сүү	305	1400
		Ноолуур	грамм	300
		Нарийн, нарийвтар ноос	кг	
		Бүдүүн, бүдүүвтэр ноос	кг	1.2
7	Малын бүртгэл мэдээллийн сан, сүлжээг бий болгох:	Сүлжээнд хамрагдсан нэгж	тоо	23
		Бүртгэлжүүлсэн мал, өссөн	хувь	2.0
8	Малыг дараах төрлийн өвчнөөс эрүүлжүүлсэн байдал Үүнд			
	Үхэр тэмээг бруцеллэз өвчнөөс эрүүлжүүлсэн урьдчилан сэргийлж тарилга хийсэн	хувь		98.0
	адууг ям болон халдварт цус багасах өвчнөөс эрүүлжүүлсэн тандалт шинжилгээгээр халдварлалтын хувь	хувь	0.28	1.5
	Сүүний үхрийг лейкоз өвчнөөс эрүүлжүүлсэн	хувь	100	100.0
	Бог малыг бруцеллэз өвчнөөс эрүүлжүүлсэн урьдчилан сэргийлж тарилга хийсэн	хувь	0	98.9
9	Сум дүүрэгт шинээр бий болсон мал эмнэлэг, ариун цэвэр эрүүл ахуйн маллан шинжилгээ хийх лабораторийн тоо	тоо	24	24.0
#	Малын өвчний оношлогооны явуулын үйлчилгээ	хувь	0	0.0
#	Малын эм, биобэлдмэл /вакцин оношлуур/-ийг дотооддоо	хувь	100	100.0
#	Улс, аймаг сумын отрын бүс нутгийн түвшинд хамгаалалтанд авсан бэлчээрийн хэмжээ	хувь	4.3	4.3
#	тэжээлийн цех	тоо	2226	1713.6
#	Бэлчээр сайжруулах арга хэмжээний хүрээнд шинээр гаргасан инженерийн хийцтэй худаг	тоо	32	22
#	малын даатгалын тогтолцоог боловсронгуй болгох ажлын хүрээнд индексжүүлсэн даатгалд хамрагдсан малчин өрх	тоо	26	*
#	Бий болгосон мал нядалгааны цех	тоо	0	3

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Хүрсэн түвшин	
			2011 он	2012 он
	Мах, нядалгааны жингээр нийт үйлдвэрлэсэн махны хэмжээ Үүнээс	мян.тн	159.9	161.9
	Үйлдвэрийн аргаар боловсруулсан	мян.тн	159.9	161.9
#	Экспортонд гаргасан	мян.тн	0	0
#	Нийт үйлдвэрлэсэн сүүний хэмжээ /үйлдвэрийн аргаар боловсруул	мян.тн	130.5	185.8

БЗА-ны дарга
МЭА-ны дарга
МҮА-ны дарга

Б.Нарантуяа
Эрдэнэцэцэг
Г.Багтулга

Дээрх хүснэгтээс харахад Монгол мал хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлууд өмнөх оноос өсөлттэй байгаа боловч тэдгээр нь шаардлагатай түвшинд хүрсэн эсэхэд үнэлэлт дүгнэлт хийж харьцуулах боломжгүй байгаа нь илэрхий байна.

1.7 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийж буй хяналт шинжилгээ, үнэлгээ бодитой биш байна.

Аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээний тасаг нь аймагт хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. Хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүн, мэдээг Засгийн газрын 2006 оны 160 дугаар тогтоол, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2009 оны 285 дугаар тогтоолоор² баталсан журмыг мөрдлөг болгон хавсралт маягтуудаар гаргасан байна. Энэхүү хяналт, шинжилгээ, үнэлгээнд “Монгол мал” хөтөлбөрийн 2011, 2012 онуудын хэрэгжилтийн байдал хамрагдсан байна. Хяналт, шинжилгээ, үнэлгээний дүнг журмын хавсралт хүснэгтийн дагуу гаргасан байдлыг үзүүлбэл:

Хүснэгт 4:

Хэрэгжилтийн товчоо

Он	Биелүүлэх хугацаа	Хяналтанд авсан заалт	Хэрэгжилтийн явц	
			Тухайн жилд хийсэн ажлын явц /хувь/	Хөтөлбөр хэрэгжсэнээс хойш хийсэн ажлын явц /хувь/
2011	2010-2015	53	87,1	69
2012			88,8	72,1

² “Үндэсний хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүн, биелэлтийг дүгнэх, мэдээлэх” журам

Хүснэгтэнд тухайн жилд хийсэн ажлын болон хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш хийсэн ажлын биелэлтийг тооцон гаргасан нь харагдаж байгаа ч хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын үзүүлэлтүүд бодитой биш байна. **Тодруулбал:**

- Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг ямар шалгуур үзүүлэлтээр тооцож үнэлсэн нь тодорхойгүй байна.
- Тухайн жилд хийсэн ажлын үр дүнг тодорхой тооцоогүй бөгөөд 2012 оны үзүүлэлтийг гаргахдаа хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойшхи ажлын явц 88,8% гарсныг тухайн жилийн ажлын явцын биелэлт гэж гаргасан байна. Улмаар энэхүү дүнтэй харьцуулан хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойшхи ажлын явцыг 72,1% гэж шууд гаргасан байна.

Энэ нь Хяналт шинжилгээ, үнэлгээний тасаг холбогдох байгууллагуудаас ирүүлсэн хөтөлбөрийн биелэлтийн дүнг нэгтгэн гаргаж байгаагаас үр дүн нь бодитой эсэхэд үнэлгээ хийгээгүйтэй холбоотой байна.

Нөгөө талаар хяналт шинжилгээ, үнэлгээний тасагт хөтөлбөрийн биелэлт гаргаж өгч байгаа аймгийн ЗДТГ-ын ХБХ-ийн мэргэжилтэн З.Отгонбаяр, ХХААЖДҮГ-ын мэргэжилтэн Я.Эрхэмбаяр нарын мэдээлэл бодитой биш байгаатай холбоотой байна.

Аймгийн Засаг даргын 2013 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 1/1323 тоот албан бичгээр аймгийн ЗДТГ-ын хэлтэс, агентлаг, байгууллага, сумдын Засаг дарга нарт үндэсний хөтөлбөр, төслийн хэрэгжилттэй холбогдуулан зөвлөмж хүргүүлсэн байна. Уг зөвлөмжинд: *“Хөтөлбөр, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт эрүүл мэндийн салбарынхаас бусад хөтөлбөрт тодорхой биш байгаа нь тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд нийгэм, эдийн засагт ямар өөрчлөлт бий болсныг хэмжиж, үнэлгээ өгөх боломжгүй байна. Зөвхөн хийхээр төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийн түвшингээр биелэлт, хэрэгжилтийг дүгнэж байгаа нь үр дүнг тодорхой илтгэхгүй, үр дүнгийн үнэлгээ хийгдэхгүйд хүргэж байна. Тиймээс үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, түүний суурь болон хүрэх түвшинг тооцоо, судалгааны үндсэн дээр тогтоож, явцын, завсрын, тодорхой үе шатны үнэлгээнүүдийг хийх боломжийг бий болгох шаардлага тулгарч байна. Үүнийг эхлүүлэх нь зүйтэй”* гэжээ. Энэ нь “Монгол мал” хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгдөн хийгдэж буй ажлуудын үр дүнд бодитой хяналт, үнэлгээ хийгдэхгүй байгааг харуулж байна.

Хүснэгт 5,6-д үзүүлсэн үзүүлэлтийг холбогдох байгууллагаас ирүүлсэн мэдээнд үндэслэн нэгтгэн гаргасан бөгөөд үнэн зөв эсэхэд ч мөн хяналт, үнэлгээ хийгээгүй байна.

Хүснэгт 5:

Хөрөнгө зарцуулсан товч дүн

/сая төгрөг/

Он	Нийт зарцуулах хөрөнгө	Тухайн жилд төсөвлөсөн хөрөнгө	Тухайн жилд зарцуулсан хөрөнгө	Хөтөлбөр хэрэгжсэнээс хойш зарцуулсан хөрөнгө
2011		19,8		57,1
2012			29,5	86,6

Хүснэгтээс харахад: АЗДТГ-ын хяналт, шинжилгээ, үнэлгээний тасаг нь 2011 онд зарцуулсан хөрөнгө болон 2012 онд төсөвлөсөн хөрөнгө тодорхойгүй, бусад дүнг зөв тооцоолж гаргаагүй байгаа нь аудитаар нотлогдож байна.

Тухайлбал: Аймгийн ХХААЖДҮГ-аас 2010-2012 онд “Монгол мал” хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн хөрөнгө оруулалтын судалгааг ирүүлсэн бөгөөд энэ нь **хүснэгт 5-т** үзүүлсэн дүнтэй харьцуулахад зөрүүтэй байна.

Хүснэгт 6

Аймгийн ХХААЖДҮГГазар								
2010-2012 ОНУУДАД МОНГОЛ МАЛ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ								
2013.06.17								
Он	Аймгийн ХХААЖДҮГ-т хөрөнгө оруулалт	Сумдын хөрөнгө оруулалт	Малын ялган тэмдэглэх хэрэгсэл	Мал эрүүлжүүлэх (авермонмек)	Ноосны урамшуулал	Мал эмнэлгээр үйлчилгээний хөлс	Бруцеллёзын үйлчилгээний хөлс	Нийт дүн
2010		73962895						73,962,895.00
2011	47062989.80	603277666.59	568832388.1		1358685340	71130000		2,648,988,384.49
2012	148795472.5	172697201.04		277624874.4	2671181824		617238550	3,887,537,921.96
ДҮН	195858462	849937763	568832388	277624874.4	4029867164	71130000	617238550	6,610,489,201.45

СУДАЛГАА ГАРГАСАН:НЯ-БО

Я.БАЯНЖАРГАЛ

Хэрэгжилт нь удааширсан болон тасарч байгаа заалтын жагсаалт

Хүснэгт 7:

Он	Заалтын агуулга	Шалтгаан/тайлбар
2012	Бүрэн найрлагат тэжээл үйлдвэрлэх бага оврын цех байгуулахад ЖДҮДС-аас зээл олгох	Иргэд төдийлэн санал ирүүлэхгүй байгаа нь техник, тоног төхөөрөмжөө яаж олох, мөн туршлага байхгүйгээс санал ирэхгүй байна.
2011	-	-

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дээрх байдлаас харахад хэрэгжилт нь удааширсан болон тасарч байгаа заалт байгаа нь энэхүү заалтыг хэрэгжүүлэхэд тодорхой арга хэмжээ авч ажиллах шаардлагатайг харуулж байна.

1.8 Зарим хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулсан байна.

Улсын төсвөөс 2012 онд 646972,3 мянган төгрөг олгосноос АХЦБӨ-ний хяналтын зардалд 13090.0 мянган төгрөгийг санхүүжүүлж 2200 адуунд шинжилгээ хийн хяналтын зардалд 6190.0 мянган төгрөг зарцуулсан байна. Эм урвалж бодис ирээгүйгээс 7786 адуунд шинжилгээ хийгдээгүй ба хяналтын зардлаас зайлшгүй шаардлагын улмаас 6900.0 мянган төгрөгөөр автоклав худалдан авсан нь *зориулалт бус зүйлд зарцуулсан* арга хэмжээ болсон байна. Автоклавыг авахдаа тендер зарлаагүй, шууд гэрээгээр Монветмед ХХК-аас худалдаж авсан байна. Улсын төсвөөс 2012 онд бруцеллёзын тарилгын зардалд 618738.5 мянган төгрөг зарцуулагдахаар санхүүжигдсэн боловч тарилгын зардлаас 1500.0 мянган төгрөгийг үхрийн гоц халдварт цээж өвчнөөр өвчилсөн 3 үхэр устгасны нөхөн олговорт зарцуулж зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.

ХХААЖДҮГазрын дарга, нягтлан бодогч нар нь Сангийн сайдын 2010 оны 48-р тушаалаар батлагдсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журмын 5.5-д заасан заалтыг зөрчиж 8400,0 мянган төгрөгийн зөрчил гаргасан байна.

1.9. Төрийн хөтөлбөр хэрэгжүүлэх албан тушаалтнуудын ажлын уялдаа хангалтгүйгээс хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн хөрөнгө оруулалтад тавих хяналт хангалтгүй байна.

Хөтөлбөрийн хүрээнд хоршоо, нэгжид хөрөнгө оруулалтаар олгож байгаа зарим хөрөнгийг аймгийн ХХААЖДҮГазар мэдэхгүй байгаагаас хөрөнгө оруулалтын ашиглалтанд тавих хяналт алдагдсан байна. *Тухайлбал:*

- ХХААХҮСайдын 2011 оны А/132 тушаалаар баталсан мал аж ахуйн чиглэлийн хоршоодод олгох хөнгөлөлттэй зээл олгох хуваарьт Хөвсгөл аймгийн Энх амьдрал ирээдүй хоршоо, өндөр хун цэн хоршоо, Баян яргайт хороодод нийт 65,0 сая төгрөг олгогдохоор батлагдсан боловч Галт сумын Баянйргайт хоршоонд хөнгөлөлттэй зээлийн 25,0 сая төгрөг олгогдоогүй байна. Энэхүү зээл олголтын талаар аймгийн ХХААЖДҮГазрын албан тушаалтнууд мэдээлэлгүй байна.
- ХХААХҮСайдын 2012 оны А/47 тушаалаар “Мал эмнэлэг үржлийн ажил үйлчилгээг эрхлэгчдийн чадавхийг сайжруулах”-д дэмжлэг үзүүлэх зорилгоор олгосон хөнгөлөлттэй зээлийг нэр бүхий 8 аж ахуйн нэгжид 40.0 сая төгрөгийг 3

жилийн хугацаатай олгосон байна. Энэхүү зээл олголтын талаар аймгийн ХХААЖДҮГазрын албан тушаалтнууд мэдээлэлгүй байна.

- ХХААХҮСайдын 2012 оны А/47 тушаалаар сумдад үйл ажиллагаа явуулж буй жишиг хоршоодыг хөрөнгө оруулалтаар дэмжих-д нэр бүхий 5 хоршоонд 45,0 сая төгрөг санхүүгийн дэмжлэгээр олгосонд аймгийн ХХААЖДҮГазарт мэдээлэлгүй орон нутгийн нэгжээс тэдгээр тавих хяналт байхгүй байна.

1.10 Хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдсэн ээмэг чанарын шаардлага хангахгүйгээс ээмэгжүүлэлт, бүртгэлийн ажил удаашралтай байна.

Хувийн хэвшлийг дэмжих, чадавхижуулах ажлын хүрээнд бүх нэгжид халдварт өвчний дуудлагын иж бүрдэл, хөргөгч, вакцины зөөврийн хөргүүр, автомас зэрэг нэгжийн өдөр тутам хэрэглэдэг багаж тоног төхөөрөмж, анхан шатны шинжилгээ хийх лабораторийн тоног төхөөрөмжийг нийлүүлж нийт 157886.0 мянган төгрөгийн хөрөнгийг олгосон байна.

2012 онд Мал эмнэлгийн албанд вакцин биобэлдмэл хадгалах, хүйтэн хэлхээг бий болгох зориулалтын тасалгаа бий болгоход 18257,9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ийлдэсийн сан хадгалах хөргүүрийг 6870.0 мянган төгрөгөөр тус тус нийлүүлсэн.

Улсын төсвийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн хөрөнгийг анхан шатны нэгжүүд болон аж ахуйн нэгжүүдэд хүлээлгэн өгсөн бөгөөд анхан шатны нэгжүүдэд олгосон хөрөнгө нь сумдын ЗДТГазрын дансанд бүртгэгдсэн, аж ахуйн нэгжүүдэд олгосон хөрөнгө нь тухайн аж ахуйн нэгжүүдэд бүртгэлтэй байдаг байна.

Сумын МЭҮТасагт нийлүүлэгдсэн автомашин ихэнх сумдын ЗДТГазрын даргын мэдэлд ашиглагдаж байна. Энэ нь сумын Мал эмнэлгийн тасаг Тамгын газарт харьяалагддаг, орон тооны жолоочгүй байгаагаас цаашид удаан ашиглагдах боломжгүй болоход хүрч байна. Хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдэж байгаа тоног төхөөрөмж нь хэрэглэгчийн саналыг авахгүйгээр бэлтгэгдэж, тэдгээр нь чанар муу, стандарт шаардлагыг хангахгүй байна.

Тухайлбал: Тайлангийн 1.9 дэх хэсэгт хүснэгтээр харуулсан РБУ тавих үүрт таваг, Шилэн хаалгатай хөргүүр LG4-198, температур чийг хэмжигч болон Био аюулгүй ажиллагааны 2-р зэрэглэлийн шүүгээ зэрэг байна.

Мөн тус хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдсэн малыг ээмэгжүүлэх, бүртгэлжүүлэх ажил нь тодорхой үр дүнд хүрч чадаагүй талаар ХХААЖДҮГ-аас дараах тайлбарыг ирүүлсэн. Үүнд:

Хөтөлбөрийн хүрээнд олгосон ээмэг нь стандарт шаардлага хангахгүй, хадаасны үзүүр мултрах, салж унах, ээмэглэгч бахь хугарах, хошуу нь хүрдэггүй, малын чих

хөлдөөх зэрэг зөрчил дутагдал гарсанаас малчид уг ажлыг үл ойшоож үзэхгүйгээр үл барам мал маллагаанд хүндрэл учруулах болсон байна.

Хувийн мал эмнэлгийн эзэд ээмэгжүүлэлтийн бүртгэлийн ажлыг үр дүн муу зохион байгуулж малын бүртгэл хөтлөлтийг хагас дутуу хөтөлдөг хайнга ханддаг, ээмэгжүүлсэн малынхаа гэрчилгээний хөтлөлтийг ирүүлэхгүйгээс малыг мэдээллийн санд оруулах ажил удаашралтай байна.

Ээмэгжүүлэх ажлын үйлчилгээний хөлсөнд адуу 246 төгрөг, үхэр 100 төгрөг, бог мал 50 төгрөг олгож байгаа нь хөдөлмөр зарцуулалт их, эрсдэлтэй ажилд хөлс бага олгож байгаа шалтгаанаар мал эмнэлгийн нэгжүүд ээмэгжүүлэлт хийх сонирхолгүй болоод байна.

Энэ нь малыг ээмэгжүүлэх, бүртгэх ажил нь үр дүн муутай байгааг харуулж байна.

Мөн эрх бүхий албан тушаалтан буюу мэргэжилтнүүдийн ярьж байгаагаас харахад хөрөнгө оруулалтаар анхан шатны нэгжүүдэд болон хэвийн мал эмнэлгүүдэд нийлүүлэгдсэн компьютерт мал тооллогын программ, бүртгэлийн программ зэргийг суулгасан боловч компьютерийн хүчин чадал муугаас дээрх программуудыг ашиглахад хүндрэлтэй байдаг байна.³

ХХААХҮСайдын 2012 оны 05-р сарын 16-ны өдрийн тушаалын 4,5-р хавсралтаар батлагдсан хуваарийн дагуу 80164,1 мянган төгрөгийн мал жинлэх, хэмжих, багаж тоног төхөөрөмж, ээмэг нь 2013 оны 3-р сард буюу 1 жилийн дараа хэрэглэгч байгууллагадаа нийлүүлэгдсэн байна. Удирдах дээд байгууллагаас нийлүүлсэн тоног төхөөрөмж нь хэрэглэгч байгууллагын захиалга, хэрэгцээ шаардлага саналыг харгалзаагүй, зарим тоног төхөөрөмж нь шаардлага хангахгүй, чанар муу байгаагаас харахад хөтөлбөрийн хөрөнгө үр дүнгүй болгоход хүргэж байна.

Тухайлбал: Хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдсэн хөргүүр, жин, иж бүрдэл, зөөврийн центрфуг, аптечка зэрэг тоног төхөөрөмжүүд нь тухайн ажлын байранд нэн шаардлагатай төхөөрөмжүүд мөн боловч аудитын хугацаанд МЭА-аас мал эмнэлгийн үйл ажиллагаа явуулж байгаа хувийн мал эмнэлгүүдэд шалгалт явуулахад сумдад нийлүүлсэн, температур чийг хэмжигч нь заавар, гарын авлагагүйгээс ашиглах боломжгүй, РБУ тавих үүрт таваг зориулалтын бус, 5ш шилэн хаалгатай хөргүүрийн шил хагарсан зэрэг зөрчил илэрсэн байна. **Үүнд:**

³ Аудитын явцад анхан шатны нэгжүүдэд болон хувийн мал эмнэлгүүдэд очиж ажиллах боломж гараагүй тул хэлэлцүүлгийн явцад мэргэжилтнүүдийн ярьж байгаа хүндрэл бэрхшээлийг тайланд тусгалаа.


Хүснэгт 7
/мян.төгрөгөөр /

Нийлүүлсэн огноо	Гэрээ байгуулсан газар	Нийлүүлсэн аж ахуйн нэгжийн нэр	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
2012	ҮХААЯ	Монгол эм Импекс ХХК	Шилэн хаалгатай хөргүүр LG4-198	5	326,8	1634,0
2011	УМЭҮГ	Монгол эм Импекс ХХК	Температур чийг хэмжигч	120	156,5	18778,6
	УМЭҮГ	Цэцүүх трейд ХХК	РБУ тавих үүрт таваг	25	6,5	162,5
Нийт дүн						20575,1

Мөн “Монгол мал” хөтөлбөрийн хүрээнд 2011 онд Цэцүүх Трейд ХХК улсын төсвийн хөрөнгөөр /төсөвт өртөг нь 17,1 сая/ Био аюулгүй ажиллагааны 2-р зэрэглэлийн шүүгээг нийлүүлсэн байна. Тус тоног төхөөрөмжийг стандартын дагуу суурилуулж өгөөгүйгээс агаар сэлгэх сэнс нь ажиллахгүй, бүрэн ашиглагдахгүй байна⁴.

2011 онд тус газарт Азийн хөгжлийн банкны ХАА-г хөгжүүлэх хөдөөгийн хөгжлийн төслөөр Био аюулгүй ажиллагааны 2-р зэрэглэлийн шүүгээг 8654,6 мянган төгрөгөөр нийлүүлсэн байх бөгөөд дээрх “шүүгээ”-тэй хүчин чадлаар ижил атал 8445,4 мянган төгрөгөөр бага үнэтэй нийлүүлэгдсэн байна. Энэ нь Улсын төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаагийн нэг илрэл гэж үзэж байна.

⁴ - Тоног төхөөрөмж худалдан авах гэрээг УМЭҮГ-аас зохион байгуулсан тул баримтыг ХХААЖДҮГазарт ирүүлээгүй байна.



2.1 Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардлагатай үйлчилгээний хөлсийг орон нутгийн төсвөөс бүрэн санхүүжүүлж чадахгүй байна.

Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон урьдчилан сэргийлэх, оношлоход шаардагдах үйлчилгээний хөлс, зайлшгүй шаардлагаар нядлуулсан тохиолдолд орон нутгийн дундаж үнийн 40%-ийг нөхөн төлөхөд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасны дагуу халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулахад шаардлагатай мал эмнэлэг, урьдчилан сэргийлэх арга хэмжээний үйлчилгээний хөлсийг орон нутгийн төсвөөс бүрэн санхүүжүүлээгүй байна. Тухайлбал:

Хүснэгт 8

Он	Хамрагдах малын тоо толгой	Шаардагдах үйлчилгээний хөлс мян. төгрөг	ОНО-оос санхүүжүүлсэн үйлчилгээний хөлс мян. төгрөг	Гүйцэтгэл /Хувиар/
2010	2392060	430772.0	190200,0	43,6
2011	2032661	373786,2	184200,0	49
2012	2025100,0	496000	395652,0	79,7

Хүснэгтээс харахад: Мал эмнэлгийн арга хэмжээнд 2010 онд 430,7 сая төгрөг, 2011 онд 373,7 сая төгрөг, 2012 онд 496,0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төлөвлөсөн бөгөөд 2010, 2011 онд 43,6-49 хувиар, 2012 оны жилийн эцэст 395,6 сая төгрөг буюу 79,7 хувиар тус тус АИТХурлаас батлаж сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлсэн байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 25 дугаар, 2012 оны 31 дүгээр тогтоолуудаар гаргасан Мал эмнэлгийн ажил үйлчилгээний төлбөрийн жишиг үнэлгээгээр тооцсон үйлчилгээний хөлсийг Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх захиалгыг аймгийн Засаг дарга Л.Цэрэнжав баталгаажуулан УМЭҮГ-т хүргүүлдэг боловч шаардлагатай хөрөнгийг бүрэн санхүүжүүлээгүй байна. /Хавсралт 3/

Тус мэдээнд үндэслэн Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь Сангийн Яаманд төсвийн төслийг хүргүүлдэг боловч Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн

хурлаар тогтоосон мал эмнэлгийн ажил үйлчилгээний төлбөрийн жишиг үнэлгээг харгалзахгүй орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр зардлыг хянаж байгаагаас дээрх нөхцөл байдал үүссэн байна.

2.2 Вакцинжуулалтын захиалгыг үндэслэн Биокомбинат ТӨҮГ нь хөрөнгө оруулалтаар нийлүүлж байна.

Мал амьтаны халдварт, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, лабораторийн шинжилгээний оношлуур, ариутгал халдваргүйжүүлэлтийн бодисын захиалгын дагуу ҮХААЯ-ны сайд, аймгийн Засаг даргын бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусган УМЭҮГ-ын Биокомбинат ТӨҮГ-тай хийсэн гэрээгээр бэлтгүүлэн нийлүүлж байна.

Халдварт өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд шаардагдах эм бэлдмэлийн захиалга дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 9

Он	Биобэлдмэлийн нэр	Зарцуулах бэлдмэл	
		Шингэн /литр/	Хатаасан /мян.тун/
2012	Вакцин	10266.3	710
	ийлдэс	748	
2011	Вакцин	12095,3	706,4
	ийлдэс	781,3	
2010	Вакцин	9424	915
	ийлдэс	1018	

Хүснэгтээс харахад: Халдварт өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд шаардагдах эм бэлдмэлийн захиалга жил бүр буурч байгаа нь өвчлөл бага гарч байгаатай холбоотой бөгөөд вакцинжуулалт болон бусад арга хэмжээ үр дүнтэй болж байгааг харуулж байна.

2.3 Лабораторийн шинжилгээнд хамрагдсан эм тарилга, вакциныг нийлүүлж байна.

Биокомбинат ТӨҮГ-аас хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдэж байгаа эм тарилга нь хүйтэн хэлхээний хөргүүртэй машинаар хүргэгдэж ирдэг бөгөөд МЭА-ны хөргүүртэй агуулахад хадгалагдаж байна. МЭАлба нь 2012 онд шаардлага хангасан хөргүүртэй агуулахтай болсон байна.

Гэрээгээр нийлүүлэгдэж байгаа малын эм, тарилга, вакцин нь “Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатор”-ын итгэмжлэгдсэн

баталгаажуулалтын албаны экспертийн дүгнэлтээр стандартын үзүүлэлт шаардлагыг хангаж байгаа эм бэлдмэл нийлүүлэгдэж байна. Эм бэлдмэлийг экспертийн дүгнэлтийг үндэслэн хүлээн авч хуваарилж байна.

2.4 Халдварт өвчний гаралт буурч байна.

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах эрүүлжүүлэх, эмчлэн сэргийлэх, оношлох, шинжлэх арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгэхээр сумын засаг дарга, аж ахуйн нэгжийн эзэдтэй гурвалсан гэрээ хийж хэрэгжүүлэн жилийн эцсийн байдлаар гүйцэтгэсэн ажлын тайланг авч ажлыг дүгнэж ажиллаж байна.

Мал амьтдын халдварт болон паразиттах өвчний мэдээг сүүлийн 3 жилээр харуулбал дараах байдалтай байна.

Халдварт болон паразиттах өвчний мэдээ

Хүснэгт 10


Өвчний төрөл	2010 он	2011 он	2012 он
Боом	21	120	20
Цусан халдвар	122	99	57
Шөвөг яр	1644	1376	149
Колибактериоз	1	19	19
ДХХ	166	530	6
Иж балнад	21	33	138
Галзуу	16	14	3
Листериоз	138	293	45
Дуут		1	11
Халдварт өвчний нийт дүн	2565	4448	503
Паразиттах өвчин	154469	64200	29690
Нийт	157034	68648	30193

Хүснэгтээс харахад: Хөвсгөл аймагт малаас хүнд дамжин халдварладаг өвчнүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд мал сүргийг боом, галзуу бруцеллёзын вакцинжуулалтанд 2010 онд 798353 толгой, 2011 онд 329329 толгой, 2012 онд 344086 толгой мал хамрагдсан байна. Сүүлийн 3 жилд халдварт болон паразиттах өвчнөөр өвчилсөн малын тоо өмнөх жилүүдээс буурсан байна.

Халдварт өвчнүүдийн голомттой газруудын малыг вакцинд хамруулснаар халдварт өвчний гаралт жил дараалан буурах хандлагатай бөгөөд ялангуяа 2012 оны хувьд 2010 оноос 19,6 хувиар, 2011 оноос 11,3 хувиар буурсан байна. Энэ нь Монгол мал хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлж байгаа халдварт болон паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ үр дүнтэй болж байгааг харуулж байна. Гэсэн ч паразиттах өвчнөөр өвчилж байгаа малын тоо халдварт өвчнөөр өвчилж байгаа малын тооноос харьцангуй их байна.

Паразиттах өвчнөөр өвчилсөн малын тоог графикаар харуулбал дараах байдалтай байна.

Зураг 1



Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15.1.3.-д малын цусны шимэгчээр үүсдэг өвчин, хамуу, шимэгч хорхойтох өвчнөөс сэргийлэхэд хэрэглэх эмийн үнэ”-ийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр заасан атал паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээ хангалтгүй, 2010, 2011 онд паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд шаардагдах бэлдмэлийг орон нутагт нийлүүлээгүй, 2012 онд 4727,3 литр авермонмекийг улсын төсвөөс нийлүүлсэн байна.

Паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамруулах мал, шаардагдах эм, бэлдмэлийн захиалга дараах байдалтай байна.

Хүснэгт 11

Арга хэмжээний нэр төрөл	Биобэлдмэлийн нэр	Зарцуулах бэлдмэл /литр/		
		2010 он	2011 он	2012 он
Угаалга	Креолин-х	2400	2200	2000
Туулгалт	Альмонзол	2800	2900	2600
Боловсруулалт	Ивомек	1260	983	900

Паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэн эм бэлдмэлийг Цагаан залаат Агвит ХХК, Хөвсгөл хүлэг ХХК, “Ди Эй Ай” ХХК, Малчин Монгол ХХК зэрэг аж ахуйн нэгжүүдээс худалдан авч бэлтгэж аж ахуйн нэгжүүдэд худалдан малчдад үйлчилгээ үзүүлж байна. Иймд паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд төрийн дэмжлэг хангалтгүй байна.

Паразиттах өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулахаар төлөвлөсөн малын тооноос их хэмжээний малыг уг арга хэмжээнд хамруулж байна. Хэрэв *Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15.1.3.-д зааснаар* паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд шаардагдах бэлдмэлийг улсын төсвөөс бүрэн санхүүжүүлбэл малчид малаа бүрэн хамруулах, ингэснээр “Монгол мал үндэсний хөтөлбөр”-т нийцсэн үр дүнтэй арга хэмжээ болох байна.

Хэлэлцүүлгийн явцад: Мэргэжилтнүүдийн ярьж байгаагаар паразиттах өвчний эсрэг арга хэмжээ тарилга /ивомек/-ыг малчин тарьж байна. Эм бодис тариа нь зах зээлээс чөлөөтэй худалдан авч малчид тун хэмжээг эмчилгээний жорын дагуу бус тарилгыг өөрөө хийж байгаа нь хөтөлбөрийн хүрээн дэх эрүүл малаас цэвэр, аюулгүй түүхий эд, бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлэх/ эрүүл хүнс/ зорилгод сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Иймд дээрх асуудлыг төрөөс зохицуулах шаардлага байгаа нь харагдаж байна.

Паразит өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний мэдээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 12

	2010 он		2011 он		2012 он	
Арга хэмжээний нэр	төлөвлөгөө мян. толгой	гүйцэтгэл мян. толгой	төлөвлөгөө мян. толгой	гүйцэтгэл мян. толгой	төлөвлөгөө мян.толгой	гүйцэтгэл мян. толгой
Угаалга	1327100	1148615	892200	504596	797200	1262798
Боловсруулалт	1113,9	644538	323000	639222	283000	3096578
Туулгалт	9915,8	1409596	727600	1096051	875700	1585998
Нийт дүн	1927750	3202749	1942800	2239869	1955900	5945374
Гүйцэтгэл		166,1%		115,2%		323%

2.5 Мал эмнэлгийн алба нь халдварт өвчний голомтын бүртгэл гаргаж хянаж байна.

Аймгийн Зооноз өвчин судлалын төв нь МХГ-тай хамтран голомтот халдварт өвчний эрсдэлийг 2010 оноос жил бүр 8 суманд сумын мал эмнэлгийн судалгаа зураглалыг үндэслэн хөрсний дээж авч Зоонозын өвчин судлалын төвд

шинжлүүлж мал эмнэлгийн алба нь GPS-р бүртгэн авч мэдээллийн сан бүрдүүлэн хяналт үнэлгээ хийж байна.

Халдварт өвчний голомттой нутгийн малыг тухайн өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин тарьж дархлаажуулан хамгаалж, халдварт өвчин гарсан тохиолдолд аймгийн Онцгой байдлын албатай хамтран ажиллаж зааврын дагуу арга хэмжээг хэрэгжүүлэн таслан зогсоож байна.

Монгол мал үндэсний хөтөлбөрийн хүрээнд олон арга хэмжээ хэрэгжүүлж байгаагийн үр дүнд бруцеллёз өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд адуунаас бусад малыг 2012 онд бүрэн хамруулж дархлаажуулан, хээлтүүлэгч малыг лабораторийн шинжилгээгээр өвчнийг нь хянасны дүнд хээлтүүлэгч малын халдварлалт 2010 онд 37, 2011 онд 112, 2012 онд 18 толгой мал илрүүлэн холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.

Боом өвчинд үхэр хамгийн өндөр эрсдэлтэй байдаг учраас аймгийн хэмжээний нийт үхрийн 90 гаруй хувийг вакцинжуулж дархлаажуулснаар 2009 онд 70 үхэр өвчилж үхсэн бол 2012 онд 20 үхэр өвчилж үхсэн нь өвчлөл 3 дахин буурсан байна. Зоонозын халдварт галзуу өвчний өвчлөл 2010 онд 16, 2011 онд 11, 2012 онд 4 мал, амьтан өвчилж тэдгээрийг устгасан байна.

Сумын МЭҮТ-ын улсын байцаагч тарилгын явцад хяналт үнэлгээ хийж, ажлын цувааг баталгаажуулан дүгнэлтийг ХХААЖДҮГазарт хүргүүлж байгаа боловч мал эмнэлгийн үйлчилгээ, эмчилгээнд МЭА-наас хянаж баталгаажуулаагүй байна.

Улсын хэмжээнд баруун 7 аймгийг /Хөвсгөл аймаг багтаж байгаа/ шүлхий өвчнөөр тайван, вакцин хэрэглэдэггүй бүсийн статусыг ДМАЭМБ-аар хүлээн зөвшөөрүүлэхийн тулд сүүлийн 3 жил дараалан тандалт шинжилгээ хийж эрүүл малыг баталгаажуулж байна.

Улсын МЭХ –ээс бруцеллёз өвчний тарилгын үр дүн, дархлааны хүчдэлийг лабораторын шинжилгээгээр баталгаажуулсан, мөн аймгийн МЭА-наас бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын явцыг 12 суманд шалгаж зөвлөсөн нь үр дүнтэй арга хэмжээ болсон байна.

ДҮГНЭЛТ

Аудитын дүн нотлох зүйлсэд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Мал аж ахуйн салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгохтой холбогдуулан тодорхой ажлууд хийгдэж байгаа ч хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүрэх түвшинг тодорхойлоогүй, хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлт тодорхой бус, хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдэж буй зарим тоног төхөөрөмж ашиглалт хамгаалалтын байдал болон ХХААЖДҮГ нь хөтөлбөрийн хүрээнд олгогдсон зарим арга хэмжээнд тавих хяналт хангалтгүй байна.
2. *Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дэх заалтад* заасан “малын цусны шимэгчээр үүсдэг өвчин, хамуу, шимэгч хорхойтох өвчнөөс сэргийлэхэд хэрэглэх эмийн үнэ”-ийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр заасан атал паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд шаардлагатай бэлдмэлийг орон нутагт нийлүүлэхгүй байгаагаас малчид өөрсдөө худалдан авч жорын дагуу тарихгүй байгаа нь эрүүл хүнсэнд сөргөөр нөлөөлж байгаа тул төрийн дэмжлэг хэрэгтэй байгааг харуулж байна.
3. *Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалтад* заасан “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон урьдчилан сэргийлэх, оношлоход шаардагдах үйлчилгээний хөлсийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэсэн заалтын дагуу үйлчилгээ, оношлогоонд шаардлагатай ажлын хөлсийг орон нутгийн төсвөөс бүрэн санхүүжүүлэхгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах албан тушаалтнуудад доорхи зөвлөмжийг хүргүүлж байна.

ҮХААЯ-ны сайд Х.Баттулгад:

- Паразиттах өвчний улмаас мал хорогдох, тарга хүч буурах, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн чанарыг бууруулах зэргээр нийгэм эдийн засагт ихээхэн хохирол учрах аюултай тул мал сүргийг паразиттах өвчнөөс эрүүлжүүлэх, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд угаалга, туулгалт, боловсруулалтанд шаардагдах эм, бэлдмэлийн санхүүжилтийг улсын төсвөөс бүрэн санхүүжүүлэх арга хэмжээг авах.
- Малчдад малчин мэргэжил эзэмшүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд хөтөлбөрийн хүрээнд эрүүл малаас цэвэр, аюулгүй түүхий эд, бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарах

ХБХ-ын дарга Х.Ган-Очир, ХХААЖДҮГазрын дарга Б.Галбадрах нарт

- Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөнд зорилтын хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлон хэрэгжилтийг хангуулан ажиллах.
- Төлөвлөгөөнд тусгагдсан заалтуудаас хэрэгжилт нь удаашралтай байгаа заалт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах.

ХХААЖДҮГазрын дарга Б.Галбадрахад:

- Сумдын мал эмнэлэг, үржлийн тасгуудыг мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангах
- Төрөөс үзүүлж байгаа мал эмнэлгийн үйлчилгээ мал бүхий иргэдэд хүрч байгаа эсэхэд тавих хяналтыг сайжруулах
- Хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдэж буй хөрөнгө нь чанарын шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавьж, шаардлага хангахгүй хөрөнгийг бүртгэлд тусгахгүй байх.

Аймгийн ЗДТГ-ын дарга Г.Төмөрбаатарт:

- Хөтөлбөрийн хэрэгжилтэнд явцын болон засврын үе шатуудад тавих хяналт, шинжилгээ, үнэлгээг бодитой болгох.

Хавсралт 1

№	Засгийн газрын баталсан төлөвлөгөө			Аймгийн Засаг даргын баталсан төлөвлөгөө
	Хэрэгжүүлэх арга зам	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжүүлэх арга зам
1	1.1.9. "Мах" дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх	ХХААХҮЯ	ҮХШХ, СХЗГ, МХЕГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, Мах үйлдвэрлэгчдийн холбоо	1.1.1 Шинээр батлагдан гарсан болон нэмэлт өөрчлөлд орсон хууль эрх зүйн актуудыг сурталчилан таниулах, хэрэгжүүлж ажиллах зохион байгуулалтын арга хэмжээ авах
2	1.1.10. "Тэмээ" дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх	ХХААХҮЯ	ҮХШХ, СХЗГ, МХЕГ, аймгийн Засаг дарга	1.1.2 Шинээр батлагдсан үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг ханган ажиллах ажлыг зохион байгуулах
3	1.1.11. "Арьс шир" дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх	ХХААХҮЯ	БСШУЯ, ҮХШХ, аймаг, нийслэлийн Засаг дарга, Арьс, шир үйлдвэрлэгчдийн холбоо	1.1.3. Малчдад бэлчээрийн мал маллагааны уламжлалт болон дэвшилтэт арга технологи эзэмшүүлэх, аж ахуйгаа үр ашигтай хөтлөх мэдлэг олгох нодāāēōūā ōyāēyē īyāyūēēēēī āāēāōōēēāāāā болон орон нутагdāē dāidōāī cīdēñ āāēāōōēāō
4	1.1.13. Нийслэл, томоохон суурин газрын орчимд сүүний аж ахуй хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	Аймаг, нийслэлийн Засаг дарга	ХХААХҮЯ	1.1.4. Малын эмч, мал зүйч хос мэргэжил эзэмшүүлэх, мэргэжилтнийг давтан сургах замаар малын эмч, мал зүйч мэргэжлээр хөрвөх чадвар эзэмшүүлэх
5	1.2.1. Сумдад мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний анхан шатны нэгжийг шинээр бий болгох асуудлыг шийдвэрлүүлэх	ХХААХҮЯ	СЯ, аймгийн Засаг дарга	1.1.5. Мал аж ахуйн мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сурad īūdāyāēēēōī;çäēēī nōāāēāāā āādāāē dāidōōēāō
6	1.2.2. Сумдын мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааны чадавхийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	ХХААХҮЯ	СЯ, аймгийн Засаг дарга	1.1.6. Õēē āāīāēī dāēāāādēāāāā, āīēñ øēīyūd nūdāyūāāyāē āóē dāēāāādd °ā÷ŕ°ñ nūdāēēēýō, īūdāyāēēēōī;çāyā īyāēyā īēāñd, nōdāāēō dēēō
7	1.2.3. Сумдын мал эмнэлэг, үржлийн нэгжийн болон мал эмнэлэг, үржлийн чиглэлээр ажил, үйлчилгээ эрхэлдэг хувийн хэвшлийн үйл ажиллагаанд тавигдах стандарт, чиг үүргийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж батлуулж мөрдөх	ХХААХҮЯ	Аймгийн Засаг дарга	1.1.7. ĪY¯-ēēī dāñāēēī īūdāyāēēēōī;çäēēā GPS-yūd dāīāāē nōdāāēōāīā dāidōōēāī nōdāāē āīēñdūā īyāyūēēēēēī nāīā ā;δdāyō
8	1.2.4. Мал эмнэлэг, үржлийн 1-2 загвар нэгжийг эхний ээлжинд аймаг бүрт бий	МЭҮГ, аймаг,	ХХААХҮЯ	1.1.8. Мал эмнэлэг, үржлийн загвар аж ахуй, мэргэжлийн баг, нэгж бий болгож, шинжлэх ухаан

**Монгол мал үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөө нь Хөвсгөл аймгийн эдийн засаг
нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдсан байдлыг хүснэгтээр харуулбал:**

Хавсралт 2

№	Монгол мал үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөө	Хөвсгөл аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	
		2011 он	2012 он
1	1.Ус дутагдалтай бэлчээр нутагт усны хайгуул хийх, бэлчээрийн усан хангамжийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгох 2.Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор инженерийн хийцтэй худаг шинээр гаргах, түүнд шаардагдах хөрөнгийн тодорхой хувийг хэрэглэгч малчдаас гаргадаг болох 3.Цас, борооны усыг тогтоож, хөв цөөрөм байгуулах үйл ажиллагааг дэмжих 4.Өөрийн хөрөнгөөр гар худаг гаргах, усан сан байгуулах зэргээр малын усан хангамжийг сайжруулсан иргэд, аж ахуй нэгжийг урамшуулах	Хөдөөгийн хүн ам, малын усан хангамжийг сайжруулах арга хэмжээ авч 10 шинэ худаг гаргаж, гар худаг гаргаж байгаа малчдыг болзлын дагуу урамшуулна.	Хөдөөгийн хүн ам, малын усан хангамжийг сайжруулах арга хэмжээ авч инженерийн хийцтэй 30 худаг шинээр гаргаж, малчдын хүчээр 30-аас доошгүй гар худаг гаргах
2	Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулдаг мэрэгч амьтантай байгаль орчинд халгүй арга, технологиор тэмцэх ажлыг зохион байгуулах	Хортон мэрэгчидтэй тэмцэх арга хэмжээ авна	5 сумын 40 мян.га талбайд бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх арга хэмжээ авна
3	1.Мал эмнэлэг, үржлийн загвар аж ахуй, мэргэжлийн баг, нэгж бий болгож, шинжлэх ухааны ололт, шинжилгээний дэвшилтэт арга зүй эзэмшүүлэх 2.Малын чанар, ашиг шимийг сайжруулах 3.Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарын хяналт, баталгаажуулалтын тогтолцоог сайжруулах	Монгол мал хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд бүх суманд мал эмнэлэг, үржлийн алба байгуулан ажиллуулж, малын чанарыг сайжруулаж, сүү, мах, ноос, ноолуурын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж мэргэжилтэй боловсон	Монгол мал хөтөлбөрийн үйл ажиллагааг эрчимжүүлэх

хүчнээр хангана			
4	Сүү, махны чиглэлийн үхэр зэрэг төрөлжсөн үүлдрийн, бүтээмж өндөртэй мал үржүүлэхэд иргэд, ах ахуйн нэгжүүдэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх	Үхэр сүрэг өсгөх аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Эрчимжсэн мал аж ахуй сүү, махны үхэр, үржүүлэгч фермерүүдэд дэмжлэг үзүүлэх
5	1.Цөм сүргийн малыг сонгон илрүүлж, чанар, стандартын шаардлага хангасан хээлтүүлэгч бойжуулах үүсгэл санаачлагыг дэмжих 2.Монголд үржүүлж байгаа баталгаажсан үүлдэр, омгийн малын ашиг шимийн түвшинг судлан тогтоож, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үржил-селекцийн ажил зохион байгуулах	Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуйг бий болгож, цөм сүргийн тоог нэмэгдүүлнэ.	Эрчимжсэн мал аж ахуй сүү, махны үхэр, үржүүлэгч фермерүүдэд дэмжлэг үзүүлэх
6	Малын эрүүл мэндийг хамгаалах /Энэ зорилтын хүрээнд МЭУ анхан шатны нэгжийн үйл ажиллагааг ОУ-ын жишигт нийцүүлэх, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэврийн асуудал, халдварт өвчинүүдтэй тэмцэх гэх мэд 12 заалтыг тусгасан байна/	Хил дамнан халдварладаг малын гоц халдварт шүлхий, адууны ханиад, хонь, ямааны цэцэг, гахайн ханиад, гахайн мялзан, шувууны томуу өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.	Малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд мал амьтан хамруулан мал сүргийг эрүүлжүүлэн, мал эмнэлгийн нэгжүүдийн чадавхийг дээшлүүлэх
7	Хадлан тэжээлийн үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх /өвс, тэжээлийн нөөцийн цэг сэргээх, хадлангийн талбайг хашиж хамгаалах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх гэх зэрэг 3 заалт/	Усалгаатай газар тариаланг дэмжиж, техник технологийн шинэчлэлтийг үргэлжлүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногоо, хадлан тэжээл бэлтгэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	1.Хадлангийн талбай, бэлчээрийг хашиж хамгаалах малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх 2:Газар тариалангийн салбарт техник, технологийн шинэчлэлтийг үргэлжлүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногоо, хадлан тэжээл бэлтгэх хүчин чадлыг нэмэгдүүлэх
8		Сумдад жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор “Үйлдвэр хөгжүүлэх	“Үйлдвэр хөгжүүлэх сан”-гийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэн зээлийн чанар үр дүнд үе шаттай хяналт мониторинг хийх

сан”-гийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлнэ.	
9 Малын бүртгэл мэдээллийн сан, сүлжээг бий болгох /2 үйл ажиллагаа төлөвлөсөн/	Малыг бүртгэлжүүлж, мэдээллийн сан бүрдүүлэх, биотехнологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх, өөрийн нутаг орон дасан зохицсон нутгийн омог хэвшлийн өндөр ашиг шим бүхий хээлтэгч, хээлтүүлэгч бэлтгэх замаар малын ашиг шимийг нэмэгдүүлэх
10 Малчдад бэлчээрийн мал маллагааны уламжлалт болон дэвшилтэт арга технологи эзэмшүүлэх, аж ахуйгаа үр ашигтай хөтлөх мэдлэг олгох сургалтыг хэвлэл мэдээллийн байгууллага болон орон нутагтай хамтран зохион байгуулах	Малчдыг эрүүл мэнд нийгмийн даатгалд хамруулах
11 Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн биржийн тогтолцоог зохих хууль тогтоомж журмын дагуу ажиллуулах, хэрэгжүүлэх	Үр тариа, үрийн буудай болон төмс хүнсний ногооны зоорь барихад дэмжлэг үзүүлэх Тариалангийн талбайн услалтын сестимийг нэмэгдүүлэх Таримал ургамлын үрийн чанар хангамжийг нэмэгдүүлэх, үрийн сорт чанарлаг байдлыг анхаарах Жимс жимсгэний суулгац бэлтгэх, тариалах, боловсруулах үйлдвэрийг дэмжих
12 МЭҮ-ийн тасгийн мэргэжилтнүүдийг GPS-ээр хангаж сургалтанд хамруулан сургаж голомтыг мэдээллийн санд бүртгэх	Шинэ дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх ААН-д дэмжлэг үзүүлэх замаар хүн амыг эрүүл ахуйн чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр хангах
13 Малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл зэрэг хамтын хөдөлмөрийн зохион байгуулалтын хэлбэрүүдийг бүх талаар дэмжих	Хоршоологчдын жилийн хүрээнд үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан, хөдөлмөрөө хоршин ажиллаж байгаа хоршоо нөхөрлөлийн хамтын ажиллагааг хөхүлэн дэмжих

Мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэврийн магадлан шинжилгээний ажлыг сумын түвшнээс эхлэн ОУ стандарт, арга зүйн дагуу гүйцэтгүүлэх	Эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр хангах Чанар стандартыг хөнгөн хүнсний салбарт мөрдөх, хяналтыг сайжруулах
---	--

Хавсралт 3

Үндэсний статистикийн газрын зөвшөөрснөөр
УМЗУ-ийн газар батлав. 2003 он №34

Аймаг, нийслэл.....**Хөвсгөл**

УМЗА маягт №59
2-р сарын 25-нд баг, хорооноос сум, дүүрэгт
2-р сарын 28-нд сум, дүүргээс аймаг, нийслэлд
3-р сарын 10-ны дотор аймаг, нийслэлээс
УМЗУГ-т маягтаар мэдээлнэ.

2011 онд халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд
хамруулах мал, үйлчилгээний хөлс

Арга хэмжээний нэр	Мөрийн дугаар	Хамрагдах мал, амьтны тоо /мян.тол/				Нэг мал тарих хөлс			Нийт зардал /мян.төг/
		бод	бог	амьтан	бүгд	бод	бог	амьтан	
Боомын вакцин	1	298.2	21.5		319.7	200	100		61790
Галзуугийн вакцин	2	27.4	9	11.5	47.9	200	100	200	8680
Цусан халдвар формал вакцин	3	167	90.2		257.2	400	200		84840
Шөөг ярын вакцин	4		215		215		100		21500
ДХХ-ын вакцин	5		309		309		200		61800
ДХХ-Энтеробактериозын хам вакцин	6		151		151		200		30200
Бруцеллёзын штам-19	7	54.7			54.7	200			10940
Бруцеллёзын рев-1	8		387		387		100		38700
Листериозын вакцин	9		138.2		138.2		200		27640
Дуут хавдрын вакцин	10	47.4			47.4	200			9480
Колибактериоз, иж балнадын хам вакцин	11		21.3		21.3		200		4260
Тугалын иж балнадаас сэргийлэх вакцин	12	1.1			1.1	400			440
Сахуугийн бактерин	13	38.1			38.1	200			7620
Шувууны томуугаас сэргийлэх вакцин	14			1.8	1.8			200	360
Гахайн цусан халдвар, иж балнадын вакцин	15			0.25	0.25			400	100
Сохор доголын вакцин	16		10.5		10.5		100		1050
Боомын ийлдэс	17	5.27			5.27	200			1054
ДХХ-ын ийлдэс	18		10.97		10.97		100		1097
Цусан халдварын ийлдэс	19	6.081			6.081	200			1216.2
Колибактериозын ийлдэс	20		8.79		8.79		100		879
Иж балнадын ийлдэс	21		1.4		1.4		100		140
ДҮН		645.251	1373.86	13.55	2032.661				373786.2

ТЭМДЭГ

Боловсруулсан: Халдвартын эмч..... / Р.Намсрайжав /

Хянаж зөвшөөрсөн: ХХААЖДУГ-ын дарга..... / Б.Наранчулуун /

Захиалгыг батлав: Аймгийн засаг дарга..... / П.Цэрэнжав /



“Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, вакцинжуулалт болон Монгол мал үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт” нийцлийн аудитын тайлан

Үндэсний статистикийн газрын зөвшөөрснөөр
УМЭҮ-ийн газар батлав.2003 он №34

УМЭА маягт № 59

2-р сарын 25-нд баг, хорооноос сум дүүрэгт, 2-р сарын 28-нд сум дүүргээс аймаг нийслэлд, 3-р сарын 10-ны дотор аймаг нийслэлээс УМЭҮГ-т маягтаар мэдээлнэ.

Аймаг, нийслэл..... **ХӨВСГӨЛ**

2010 онд халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах мал, үйлчилгээний хөлс

Арга хэмжээний нэр	Мөрийн дугаар	Хамрагдах мал амьтны тоо				Нэг мал тарих хөлс			Нийт зардал /мян.төг/
		бод	бог	амьтан	бүгд	бод	бог	амьтан	
Боомын вакцин	1	322.5	41.5		364	200	100		68650
Цусан халдварын формал вакцин	2	186.6	90.6		277.2	400	200		92760
ДХХ-ын вакцин	3		381.5		381.5		200		76300
ДХХ энтеробактериозын вакцин	4		185		185		200		37000
Дуут хавдрын вакцин	5	64.72			64.72	200			12944
Галзуугийн вакцин	6	60.4	14.7	7.6	82.7	200	100	200	15070
Сахуугийн бактерин	7	32.9			32.9	200			6580
Листериозын вакцин	8		145.2		145.2		200		29040
Бруцеллёзын штамм-19	9	61			61	200			12200
Бруцеллёзын рев-1	10		472.8		472.8		100		47280
Шевег ярын вакцин	11		302.1		302.1		100		30210
Колибактериоз иж балнад	12		13		13		100		1300
Тугалын иж балнад	13	0.6			0.6	200			120
Сохор доголын вакцин	14		5.5		5.5		100		550
Гахайн цусан халдвар иж балнад	15			1.22	1.22			200	244
Гахайн мялзангаас сэргийлэх	16			0.3	0.3			200	60
Шувууны томуугийн вакцин	17			2.32	2.32			200	464
Тарилгын дүн		728.7	1651.9	11.44	2392.06				430772

Боловсруулсан:  / Р.Намсрайжав /

ТЭМДЭГ Хянаж зөвшөөрсөн: ХХААЖДҮГ-ын дарга  / Д.Батчулуун /

Захиалгыг батлав. Аймгийн засаг дарга  / Л.Цэрэнжав /

Холбогдох байгууллагын санал

Аудитын төгсгөлд холбогдох байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудтай хэлэлцүүлэг зохион байгуулж гарсан саналыг тайланд тусгасан болно.